



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 11 сарын 24 өдөр

Дугаар А/78

Улаанбаатар хот

### Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гоо билэгүүд ХХК-ийн “Гэгээ” зочид буудлын 20/351, Жи би эс импэкс ХХК -ийн “Хабу” зочид буудлын 20/202, Шатар-Оюун ХХК-ийн “Номадо бютик” зочид буудлын 20/460, Цогт өргөө-Од ХХК-ийн “Цогт баян” зочид буудлын 20/450, Ти Си Эй ХХК-ийн “Титэм” зочид буудлын 20/393, Мон цацраг ХХК-ийн “Сэлбэ” дэн буудлын 20/340, Зориг халиун ХХК-ийн “Бэлх” дэн буудлын 20/141, Мудагуга ХХК-ийн “Лила” дэн буудлын 20/408 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Х.Содномдэмбэрэл/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

6. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА



А.АРИУНГЭРЭЛ

1150500329



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2021 оны 11 сарын  
24-ны өдрийн А/78 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-8936 1118203502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр


Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Гоо билэгүүд ХХК	5436354	Гэгээ	БГД-ийн, 22-р хороо, Зүүннارانгийн 18-р гудамж 70 тоот
2	Жи би эс импэкс ХХК	2767864	Хабу	БГД-ийн, 1-р хороо, Замчдын 48а
3	Шатар-Оюун ХХК	6149391	Номадо Бютик	БГД-ийн, 16-р хороо, Амарсанаагийн гудамж 48/2 тоот
4	Цогт өргөө-Од ХХК	2857405	Цогт баян	СБД-ийн 11-р хороо, Цагдаагийн гудамж
5	Ти Си Эй ХХК	6580262	Титэм	БЗД-ийн, 18-р хороо, Намьяанжүгийн гудамж 3 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2021 оны 11 сарын  
24-ны өдрийн А/78 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2021 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Мон цацраг ХХК	2543842	Сэлбэ	СБД-ийн, 12-р хороо, Хангайн 22-831
2	Шинэ жигүүр ХХК	5339685	Кровн	СБД-ийн, 9-р хороо, 7-р хороолол Старт центрийн байранд
3	Зориг халиун ХХК	5037298	Бэлх	СБД-ийн, 18-р хороо 35-51а тоот
4	Мудагуга ХХК	5832012	Лила	БЗД-ийн, 4-р хороо, Доржийн гудамж 48/3 тоот

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР